

**СУДАЛГАА ХӨГЖИЛ, ИННОВАЦИ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТНИЙ  
АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

**А. ТАНИЛЦУУЛГА**

<b>1. Байгууллагын нэр:</b> “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” Орон Нутгийн Өмчит Төсөвт Үйлдвэрийн Газар	<b>2. Нэгжийн нэр:</b> Үйлдвэрлэл, технологийн алба
<b>3. Ажлын байрны нэр:</b> Судалгаа хөгжил, инноваци хариуцсан мэргэжилтэн	<b>3.1 Албан тушаалын ангилал:</b> БҮТП ОНӨТҮГ-ын даргын 2018 оны 1 сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар
<b>4. Ажлын байрыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:</b> Ахлах мэргэжилтэн	<b>4.1 Албан тушаалын ангилал:</b> БҮТП ОНӨТҮГ-ын даргын 2018 оны 1 сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар
<b>5. Ажлын байрны шууд харьяалан удирдах албан тушаалын нэр</b> -	<b>5.1 Албан тушаалын ангилал:</b> -

**Б. ЧИГ ҮҮРЭГ**

<b>1. Ажлын байрны зорилго</b>	Үйлдвэрлэл, технологийн паркийн урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогыг боловсруулах, мөн парк, түүний нэгжүүдийн тогтвортой хөгжилд чиглэсэн судалгаа, шинжилгээ, инновацийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдийг төлөвлөх, тэдгээрийн хэрэгжилтийг хангах, гадаад орнуудын сайн туршлагыг судалж нэвтрүүлэх, паркад болон паркийн нэгжүүдэд байгальд ээлтэй шинэ, дэвшилтэт, өндөр технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх ажлуудыг дэмжих, оюуны өмчийг баталгаажуулах, эдийн засгийн эргэлтэд оруулах, мэдлэгийн эдийн засгийг бий болгохтой холбоотой чиг үүргүүдийг хэрэгжүүлэх
<b>2. Ажлын байрны үндсэн зорилт</b>	<b>2.1. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</b>
1. Үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх чиглэлээр бүх төрлийн судалгаа хийх, хөгжлийн хөтөлбөр, төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах	1. Үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх чиглэлээр судалгаа хийн, хөгжлийн хөтөлбөр, төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөж, хэрэгжилтийг зохион байгуулсан байна.
2. Парк, түүний нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэлээр гадаад дотоодын туршлага судлах, нэвтрүүлэх	2. Парк, түүний нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэлээр гадаад дотоодын туршлага судлан, нэвтрүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.
3. Паркад шинэ болон өндөр технологи нэвтрүүлэх, инновацитай холбоотой чиг үүргүүдийг хэрэгжүүлэх	3. Паркад шинэ болон өндөр технологи нэвтрүүлэх, инновацитай холбоотой тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн

3. Ажлын байрны гол үйл ажиллагаа	3.1. Хугацаа, Хувиар
<p><b><u>Ажлын байрны нэгдүгээр үндсэн зорилтын хүрээнд:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Үйлдвэрлэл, технологийн парк хөгжүүлэх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үр дүнг үнэлэх, тайлагнах</li> <li>- Үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх чиглэлээр бүх төрлийн судалгаа, шинжилгээ хийх, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах</li> <li>- Паркийг хөгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөх, шаардлагатай бичиг баримтуудыг боловсруулах, хэрэгжилтийг хангах, үр дүнг үнэлэх, тайлагнах</li> <li>- Паркийн болон паркийн нэгжүүдийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, урт, дунд, богино хугацааны төлөвлөлтийг хийхэд шаардлагатай бүх төрлийн нөөцийн судалгаа хийж мэдээллийн сан бүрдүүлэх</li> <li>- Паркийг хөгжүүлэхтэй холбоотой иргэн, хуулийн этгээдийн шинэ, шинэлэг санааг судалж үр ашигтай, дэвшилтэт технологийг сонгон авч зохих үе шаттай хэрэгжүүлэх талаар санал боловсруулж, танилцуулах</li> <li>- Паркийг бүс нутгийн болон хөрш орнуудын хөгжлийн бодлоготой уялдуулан хөгжүүлэх бодлого, түүнийг хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдийг боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг үнэлэх</li> <li>- Паркийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөг таниулах, шинэ техник, технологийн талаар иргэд, олон нийтэд чиглэсэн сургалтууд зохион байгуулах, зөвлөгөө өгөх, мэргэжилт арга зүйн туслалцаа үзүүлэх</li> </ul>	25
<p><b><u>Ажлын байрны хоёрдугаар үндсэн зорилтын хүрээнд:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Парк, түүний нэгжүүдийн бүтэээмж, ашигт ажиллагаа, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх боломж, энэ чиглэлийн гадаад орнуудын туршлагыг судлах, тодорхой шийдлийн санал боловсруулах, танилцуулах, хэрэгжүүлэхэд дэмжин туслах</li> <li>- Паркийн нэгжүүдийн үйл ажиллагааны салбарт гарч буй шинэ технологиудыг байнга судлах, салбарын эрдэмтэн судлаачид, эрдэм шинжилгээ, судалгааны баг, байгууллагатай хамтран ажиллах, судалгааны үр дүнд үндэслэн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх</li> <li>- Шинээр үйлдвэрлэлд нэвтрүүлж буй техник, технологийн мэдээллийн талаар гадаад, дотоодын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох</li> <li>- Гадаад орнуудын болон өөрийн орны бусад паркуудын сайн туршлагыг судалж, нэвтрүүлэх боломжтой төсөл, арга хэмжээ, санаа, шийдэл, санаачилгыг сонгон авч зохих үе шаттай хэрэгжүүлэх талаар санал боловсруулж, танилцуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хянах, үр дүнг үнэлж, дүгнэх</li> <li>- Өндөр хөгжилтэй орнуудын инновацийн үйл ажиллагаа, интерншип хэлбэрийн арга туршлагатай танилцаж туршлага судлах, паркийн нэгжүүд болон их дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын хамтын ажиллагаа хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг дүгнэх</li> <li>- Паркийн нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэлээр гадаад орнуудын</li> </ul>	25

туршлагыг судалж, сайн туршлагыг нэвтрүүлэх боломж, алдааг давтахгүй байх, тохиолдож болох эрсдлээс сэргийлэхтэй холбоотой мэдээлэл, холбогдох бичиг баримт, материалаар хангах, зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд холбож өгөх

**Ажлын байрны гуравдугаар үндсэн зорилтын хүрээнд:**

- Байгаль орчинд ээлтэй, бүс нутгийн нийгэм, эдийн засагт үр өгөөжтэй, ажлын байрыг олноор нь бий болгох, импортыг орлох, экспортын бүтээгдэхүүний нэр төрөл хэмжээг нэмэгдүүлэх технологиудыг судлан өндөр үр ашигтай тэргүүний технологийг сонгон авч зохих үе шаттай хэрэгжүүлэх талаар санал боловсруулж, холбогдох дээд байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх
- Өндөр технологи нэвтрүүлэх, хөгжүүлэх, мэдлэгийн эдийн засгийг бий болгох, оюуны өмчийг эргэлтэнд оруулахад чиглэсэн төслүүдийг сонгон судалж, хэрэгжүүлэх ажлыг дэмжих
- Паркийн нэгжүүдийн өнөөгийн технологийн түвшний үнэлгээ хийж, дэвшилтэт технологи нэвтрүүлэх боломж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлон, дүгнэлт гаргах
- Паркийн нэгжүүд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх нөөц, боломжийг судлах, шийдлийн санал боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжин тусалж, хамтран ажиллах
- Паркийн нэгжүүдийн шинэ технологи боловсруулах, техник тоног төхөөрөмж зохион бүтээх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлуудыг бүх талаар дэмжин туслах
- Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг дэмжих экотехнологийн судалгаа шинжилгээ хийх, экосистемийн тэнцвэрийг хангахад чиглэсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдийг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг үнэлэх
- Паркийн хэмжээнд шинжлэх ухаан, технологи, инноваци, оюуны өмчийн баталгаажуулалт, патентжуулалтын чиглэлийн хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангах, холбогдох дүрэм, журам, заавар, стандартыг мөрдүүлэх ажлыг зохион байгуулах, энэ чиглэлээр гарын авлага, материал боловсруулах, сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх
- Оюуны бүтээл, судалгаа, шинэ техник технологи, венчур төслүүдийн мэдээллийн сан бүрдүүлж, паркийн нэгжүүд болон сонирхогч бүх талуудад зохих журмын дагуу ашиглуулах
- Паркийн хэмжээнд бизнес, инновацийг хөгжүүлэх бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх
- Паркийн өндөр технологийн чиглэлийн эрдэм шинжилгээний лаборатори, материаллаг баазыг бэхжүүлэхтэй холбоотой ажлыг зохион байгуулах
- Бизнесийн төсөл, төлөвлөгөөг боловсруулах, төслийг удирдах, гүйцэтгэлд хяналт тавих
- Шинэ, дэвшилтэт, өндөр технологийн болон инновацийн зөвлөх үйлчилгээний бодлогыг мэргэжлийн удирдлагаар хангах
- Оюуны капиталыг бизнесийн эргэлтэнд оруулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, эрдэмтэд, судлаач багш, оюутнуудын судалгааны ажлын үр дүнг дэмжин урамшуулж ажиллах
- Инновацийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, технологи бизнесийн

<p>инкубаторуудыг байгуулах, уг чиглэлд гадаад, дотоодын их дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын нөөц боломжийг дайчлан ашиглах</p> <p><b><u>Ажлын байрны зорилгын хүрээнд явуулах бусад үйл ажиллагаа:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Цаг үеийн, нийгмийн болон бусад ажлуудад оролцох</li> <li>- Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай сайн биелүүлж ажлын гүйцэтгэл, үр дүнг тогтмол тайлагнах</li> <li>- Холбогдох үйл ажиллагааны чиглэлээр ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах</li> <li>- Ажлын байрыг шууд харьяалан удирдах албан тушаалтнаар ажлын төлөвлөгөөг хянуулах, биелэлтийг тайлагнах</li> <li>- Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримтыг заасан хугацаанд архивт шилжүүлж байх</li> <li>- Ажлаас чөлөөлөгдөх, өөрчлөгдөх тохиолдолд архивын баримтыг дараагийн ажилтанд буюу архивын ажилтанд албан ёсоор хүлээлгэж өгч байх</li> <li>- Ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажлын цаг ашиглалт, хугацааг чанд мөрдөн, идэвхи зүтгэлтэй, санаачилгатай, ажлынхаа бүтээмжийг нэмэгдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, үр дүнтэй ажиллах</li> <li>- Байгууллагынхаа нийтлэг зорилгод хүрэхийн төлөө өөрөө санаачилгатай, бүтээлч байхын зэрэгцээ бусдын санал санаачилгыг дэмжиж ажиллах</li> <li>- Байгууллага, нэгжээс зохион байгуулж байгаа аливаа сургалт, мэдээллийн арга хэмжээнүүдэд бүрэн хамрагдах</li> <li>- Төрийн үйлчилгээг үзүүлэхдээ иргэдийг ялгаварлахгүй хандаж, хүнд суртал гаргах, чирэгдүүлэх зэрэг үйл хөдлөлийг хориглох</li> <li>- Өөрийн боловсрол, мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлж ажиллах</li> <li>- Хөдөлмөрийн дотоод журмын дагуу чөлөөтэй, ээлжийн амралттай, өвчтэй, томилолттой гэх мэт эзгүй байх хугацаанд Судалгаа хөгжил, инноваци хариуцсан мэргэжилтний үүрэгт ажлыг Дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн хариуцан гүйцэтгэнэ.</li> </ul>	25
---	----

**В.ТАВИГДАХ ШААРДЛАГА**

<b>1.Ажлын байранд тавигдах шаардлага</b>	<b>1.1.Ерөнхий шаардлага</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Чухал шаардлагатай</b>	<b>Шаардлагатай</b>
		<b>Боловсрол</b>	Дээд, Магистрын зэрэгтэй	Докторын зэрэгтэй бол давуу тал болно.
		<b>Мэргэжил</b>	Инженер, технологи, төлөвлөлт	Эдийн засаг, удирдлага, зохион бүтээлт
		<b>Мэргэшил</b>	Судалгаа шинжилгээ, оюуны өмч	Загварчлал
		<b>Туршлага</b>	- Мэргэжлээрээ 10-с доошгүй жил ажилласан - Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын туршлагатай байх	

		<p style="text-align: center;"><b>Урчадвар</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Англи хэлний өндөр мэдлэгтэй</li> <li>- Харилцааны соёл, ур чадвар өндөртэй</li> <li>- Ажлын үр дүнгээ бусдад зөв тайлбарлаж, тодорхой ойлгуулах чадвартай байх</li> <li>- Системт сэтгэлгээтэй, загварчлах чадвартай</li> <li>- Техник, технологийн чиглэлээр өргөн хүрээний мэдлэгтэй</li> <li>- Шийдэл, шийдвэр гаргах чадвартай</li> <li>- Бичиг баримт боловсруулах өндөр чадвартай</li> <li>- Багаар ажиллах чадвартай</li> <li>- Компьютерийн өргөн хэрэглээний програмуудыг бүрэн эзэмшсэн</li> </ul>	Бусад хэлний мэдлэгтэй бол давуу тал болно.
	<b>1.2. Тусгай шаардлага:</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Ёс зүйтэй</li> <li>- Санаачлагатай, бүтээлч сэтгэлгээтэй</li> <li>- Ачаалал даах чадвартай байх</li> </ul>	Шинэ технологи судлах сонирхолтой

## Г. ХҮЧИН ЗҮЙЛС

<b>1. Ажлын байрны харилцах субъект</b>		
<b>1.1. Байгууллагын дотор талд байгаа</b>	<b>1.2. Байгууллагын гадна талд байгаа</b>	
- Байгууллагын дарга, ахлах мэргэжилтэн болон нийт ажилтнууд	<ul style="list-style-type: none"> <li>- Бүх шатны төрийн байгууллагууд, нийслэл, түүний бүтцийн байгууллагууд, ажлын байрны чиг үүрэгтэй холбоотой бусад харилцагч байгууллагууд</li> <li>- Паркийн нэгжүүд</li> <li>- Иргэд, олон нийт болон бусад</li> </ul>	
<b>2. Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Өөрийн ажлыг байгууллагын дарга, ахлах мэргэжилтний өмнө хариуцаж, шаардлагыг бүрэн биелүүлнэ.</li> <li>- Байгууллагын дотоод журам, бусад Монгол улсын хууль, тогтоомж, дүрэм журамд заасныг хатуу баримтална.</li> </ul>	
<b>3. Ажлын байрны нөөц, хэрэгсэл</b>	<b>3.1. Санхүүгийн</b>	Байгууллагын дотоод журам, Монгол улсын хууль тогтоомж, бусад дүрэм журмын хүрээнд нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ажлын үр дүнгийн урамшууллыг олгох

	<b>3.2.Биет хөрөнгийн</b>	Байгууллагын дотоод сүлжээ болон интернэтэд холбогдсон компьютер, суурин утас, бусад шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, холбогдох ном, сэтгүүл, гарын авлага
	<b>3.3.Хүний</b>	Байгууллагын нийт ажилтнууд
	<b>3.4.Бусад</b>	
<b>4. Ажлын байрны нөхцөл</b>	<b>4.1.Ердийн нөхцөл</b>	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлага хангасан хэвийн нөхцөл
	<b>4.2.Онцгой нөхцөл</b>	- Шаардлагатай үед илүү цагаар болон амралтын өдрүүдээр ажиллах, мөн орон нутагт ажиллах, - Байгууллагын нууц хадгалах

#### Д.БАТАЛГААЖУУЛАЛТ

<b>Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан ажлын хэсэг буюу багийн ахлагч:</b>	<b>Ажлын байрны тодорхойлолтыг баталсан:</b>
<p>Албан тушаалын нэр: "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-ын Ахлах мэргэжилтэн</p> <p>..... /Д.Алтангэрэл/ ( Гарын үсэг)</p> <p>2018... оны 03 дугаар сарын 16 -ны өдөр</p>	<p>Албан тушаалын нэр: "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-ын дарга</p> <p>..... /Ч.Элбэгсайхан/ ( Гарын үсэг)</p> <p>2018... оны 03 дугаар сарын 16 -ны өдөр</p>

